ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/138/НА/СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2022 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг narmandakhd@audit.gov.mn<br>Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. Аудитын санал дүгнэлт ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
3. Аудитын тайлан ........ 10
   3.1 Ерөнхий зүйл ........ 10
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
   3.4 Материаллаг байдал ........ 11
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 11
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
   3.8 Аудитын гол асуудал ........ 13
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 132
4. Аудитын илрүүлэлт ........ 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 14


2117144066
ХТҮ4037 9030891

2117144066
ХТУ4037 9030891

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГ | Засгийн газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

2117144066
ХТҮ4037 9030891

## 1.Аудитын санал дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000 Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг
ЗДТГ-ын II байр. Утас/Факс: 7058-4203

2022.02.15 № 49

танай ____ -ны № ____ -т

ХЭРЛЭН СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ОТГОН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020808

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **25,589,411.50** | **62,363,677.70** |
| **33** | **АВЛАГА** | 389,642.00 | |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 389,642.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 25,199,769.50 | 62,363,677.70 |
| **354** | **Хангамжийн материал** | 25,199,769.50 | 62,363,677.70 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 25,199,769.50 | 62,363,677.70 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **247,540,008.68** | **399,160,415.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 247,540,008.68 | 399,160,415.12 |
| **392** | **Биет хөрөнгө** | 93,244,008.68 | 244,864,415.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 51,266,719.00 | 199,852,628.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -12,674,994.96 | -19,012,492.44 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 37,719,029.50 | 23,095,293.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -24,166,293.36 | -14,759,251.45 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 69,822,110.00 | 50,634,365.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -32,722,740.87 | -27,793,665.27 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,950,768.00 | 38,450,768.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,950,588.63 | -5,603,229.72 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 154,296,000.00 | 154,296,000.00 |
| 39301 | Програм хангамж | 690,000.00 | |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -690,000.00 | |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 154,296,000.00 | 154,296,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **273,129,420.18** | **461,524,092.82** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **389,642.00** | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 389,642.00 | |
| **413** | **Өглөг** | 389,642.00 | |
| **4136** | **Бусад өглөг** | 389,642.00 | |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 389,642.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **272,739,778.18** | **461,524,092.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 272,739,778.18 | 461,524,092.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 458,325,057.88 | 458,325,057.88 |
| 51101 | Өмч: - төрийн | 304,029,057.88 | 304,029,057.88 |
| 51103 | - хувьцаат | 154,296,000.00 | 154,296,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -217,511,152.59 | -28,726,837.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -217,511,152.59 | -217,511,152.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 188,784,314.64 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 31,925,872.89 | 31,925,872.89 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **273,129,420.18** | **461,524,092.82** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **343,424,707.00** | **607,436,312.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,722,907.00** | **234,952,437.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 926,927.00 | 35,965,828.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 926,927.00 | 35,965,828.70 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 926,927.00 | 35,965,828.70 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 13,791,780.00 | 181,015,909.00 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 13,791,780.00 | 181,015,909.00 |
| 121002 | Өмч хувьчлалын орлого | | |
| **122** | **Тусламжийн орлого** | 17,004,200.00 | 17,970,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **678,500.00** | **45,164,975.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 311,023,300.00 | 327,318,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 678,500.00 | 45,164,975.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 678,500.00 | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 43,324,875.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 840,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **356,585,999.85** | **409,666,137.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **356,585,999.85** | **409,666,137.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 350,247,226.85 | 352,122,034.26 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,322,700.00 | 253,541,974.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,824,948.00 | 167,755,770.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,310,044.00 | 66,781,349.00 |
| 210104 | Урамшуулал | 19,187,708.00 | 19,004,855.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,290,100.00 | 34,289,047.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,277,400.00 | 24,190,160.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,503,100.00 | 2,642,312.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,002,600.00 | 2,083,489.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 500,600.00 | 485,723.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,006,400.00 | 4,887,363.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,733,149.00 | 16,251,610.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,651,924.00 | 3,822,096.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,228,890.00 | 7,536,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,852,335.00 | 4,892,834.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,575,056.00 | 7,054,364.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 386,500.00 | 671,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 939,600.00 | 1,009,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 120,000.00 | 315,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 202,600.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 646,100.00 | 2,516,416.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,280,256.00 | 2,541,648.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,501,378.00 | 17,804,097.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 502,000.00 | 112,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,505,878.00 | 16,500,825.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,493,500.00 | 1,191,272.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,270,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,270,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 365,200.00 | 805,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 365,200.00 | 805,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,189,643.85 | 21,875,741.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,071,300.00 | 1,266,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 28,118,343.85 | 20,409,641.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,338,773.00 | 57,544,103.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 43,418,459.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 32,788,201.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 10,230,258.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,338,773.00 | 14,125,644.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,338,773.00 | 14,125,644.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-13,161,292.85** | **197,770,175.44** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 8,985,860.80 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 8,985,860.80 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | -8,985,860.80 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-13,161,292.85** | **188,784,314.64** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **458,325,057.88** | **31,925,872.89** | **-217,511,152.59** | 272,739,778.18 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **458,325,057.88** | **31,925,872.89** | **-217,511,152.59** | 272,739,778.18 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **458,325,057.88** | **31,925,872.89** | **-217,511,152.59** | 272,739,778.18 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 188,784,314.64 | 188,784,314.64 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **458,325,057.88** | **31,925,872.89** | **-28,726,837.95** | **461,524,092.82** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **328,706,000.00** | **390,454,575.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **17,004,200.00** | **17,970,700.00** |
| **122** | **Тусламжийн орлого** | 17,004,200.00 | 17,970,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **311,701,800.00** | **372,483,875.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 311,023,300.00 | 327,318,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 678,500.00 | 45,164,975.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 678,500.00 | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 43,324,875.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 840,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **328,706,000.00** | **390,454,575.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **328,706,000.00** | **390,454,575.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **322,367,227.00** | **332,910,472.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 250,322,700.00 | 253,541,974.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,824,948.00 | 167,755,770.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,310,044.00 | 66,781,349.00 |
| 210104 | Урамшуулал | 19,187,708.00 | 19,004,855.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,290,100.00 | 34,289,047.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,277,400.00 | 24,190,160.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,503,100.00 | 2,642,312.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,002,600.00 | 2,083,489.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 500,600.00 | 485,723.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,006,400.00 | 4,887,363.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,733,149.00 | 16,251,610.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,651,924.00 | 3,822,096.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,228,890.00 | 7,536,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,852,335.00 | 4,892,834.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,633,500.00 | 7,675,116.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 316,500.00 | 671,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 939,600.00 | 1,009,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 120,000.00 | 315,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 202,400.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 646,100.00 | 1,296,416.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,408,900.00 | 4,382,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,681,278.00 | 18,076,225.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 712,000.00 | 212,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,505,878.00 | 16,500,825.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,463,400.00 | 1,363,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,270,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,270,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 365,200.00 | 805,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 365,200.00 | 805,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,071,300.00 | 1,771,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,071,300.00 | 1,571,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,338,773.00** | **57,544,103.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 43,418,459.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 32,788,201.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 10,230,258.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,338,773.00 | 14,125,644.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,338,773.00 | 14,125,644.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 345,289,600.00 | 331,163,956.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 345,289,600.00 | 331,163,956.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 344,889,600.00 | 330,763,956.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 265,029,100.00 | 253,541,974.00 |
| 210101 | Үндсэн цалин | 178,206,000.00 | 167,755,770.00 |
| 210102 | Нэмэгдэл | 65,171,800.00 | 66,781,349.00 |
| 210104 | Урамшуулал | 21,651,300.00 | 19,004,855.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,473,100.00 | 34,289,047.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,871,600.00 | 24,190,160.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,650,400.00 | 2,642,312.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,120,200.00 | 2,083,489.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 530,200.00 | 485,723.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,300,700.00 | 4,887,363.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,470,700.00 | 16,251,610.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,195,600.00 | 3,822,096.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,251,000.00 | 7,536,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,024,100.00 | 4,892,834.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,728,600.00 | 5,728,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 516,500.00 | 671,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,009,800.00 | 1,009,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 740,000.00 | 315,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,190,000.00 | 1,190,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,272,300.00 | 2,542,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,311,600.00 | 18,076,225.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 212,000.00 | 212,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,736,200.00 | 16,500,825.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,363,400.00 | 1,363,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 805,200.00 | 805,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 805,200.00 | 805,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1571300.00 | 1571300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,571,300.00 | 1,571,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 400000.00 | 400000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 400,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 345,289,600.00 | 331,163,956.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 327,318,900.00 | 314,412,346.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 327,318,900.00 | 314,412,346.00 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 17,970,700.00 | 16,751,610.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 41 | 26 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 25 | 15 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 10 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **44,324,875.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **44,324,875.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,306,416.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,106,416.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 106,416.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 200,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 43018459.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,018,459.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,788,201.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 10,230,258.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 45164975.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 45,164,975.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,324,875.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 840,100.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар

болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 356.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 62.4 сая төгрөг болж 37.2 сая төгрөгөөр өссөн нь Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй

31.3 сая төгрөгийн эд хөрөнгийг бараа материал дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 466.2 сая төгрөг болж 144.6 сая төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 148.6 сая төгрөгийн цэцэрлэгийн барилгын их засварын ажил хийгдэж, дансны үнийг нэмэгдүүлсэн, 30.5 сая төгрөгийн гаднах модон тоглоом, 1.9 сая төгрөгийн зөөврийн компьютер орлогод авч, 31.3 сая төгрөгийн хөрөнгө бараа материал дансанд шилжүүлсэн, 5.1 сая төгрөгийн хөрөнгө актлалсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 264.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого болон тусламж санхүүжилтийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 53.1 сая төгрөгөөр өссөн нь 32.8 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад олгосон мөнгөн тэтгэмж, 10.2 сая төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад үзүүлсэн дэмжлэг болон бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 387.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 387.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 327.3 сая төгрөгийн төсөв баталснаас 17.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 327.3 сая, орон нутгийн төсвөөс 17.9 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 345.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 331.1 сая төгрөг буюу 95.9 хувийн гүйцэтгэлтэй буюу 14.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Туслах аж ахуйгаас 0.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 43.3 сая, хандив тусламжийн орлого 1.0 сая нийт 45.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нэг удаагийн тэтгэмжийн зардалд 43.0 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 1.3 сая төгрөгийг тус тус зарцуулж, 0.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2021 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 149.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 148.6 сая төгрөгийн зөрчилд залруулга хийж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 4.1 Залруулсан алдаа

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр цэцэрлэгийн барилгад хийсэн 148.6 сая төгрөгийн их засварыг хүлээн авч, бараа материалаар бүртгэсэн байсныг залруулж, тус хөрөнгийг капиталжуулж барилгын дансны үнийг нэмэгдүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Бараа материал худалдан авч, орлогодсон нь төлбөрийн баримтын цахим систем дэх баримттай нэр төрлийн хувьд зөрүүтэй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтын НХМаягт ТМ-5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм......Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хэрлэн сумын 6 дугаар цэцэрлэг | 2 | 149.0 | 1 | 148.6 | 1 | 0.4 | | | | |